

Хурлын тэмдэглэл

“Айтүүлс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн **“COVID-19” коронавируст халдвар дэгдсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цугларуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцоог хангуулах зэргээр ээлжит хурлыг өөрийн онцлогт тохирсон боломжтой хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй** гэсэн мэдэгдлийн дагуу “Айтүүлс” ХК-ийн фэйсбүүк пэйж хуудсаар live хэлбэрээр шууд дамжуулагдсан. Цахим хурал 15:00-16:45 цагийн хооронд болов.

Хуралд оролцсон:

Хурлын дарга: А. Баттамир
ТУЗ-ийн гишүүн: Н. Улаанхүү, Г. Хатанболд
Гүйцэтгэх захирал: Б. Тамир
Хурлын тооллогын комисс: Л. Цэрэн-Очир, Э. Онон
Хурал зохион байгуулах комисс: Б. Ариунзул, Б. Хулан, Д. Билэгжаргал

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг танилцуулах
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох, төсвийг батлах
4. Компанийн дүрмийг шинэчлэн батлах
5. Их хэмжээний хэлцэл хийх тухай

ХУРЛЫН ИРЦ:

“Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд 17,838,217 ширхэг хувьцааг эзэмшдэг 28 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон буюу 51.64%-ийн ирцтэйгээр хурал хүчин төгөлдөрт тооцогдов.

-Хурлын дарга А. Баттамир хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулсны дараа, тооллогын комиссын дарга Л. Цэрэн-Очир хурлын ирцийг танилцуулж хурлыг хүчин төгөлдөр эхэлж байгааг мэдэгдснээр хурал эхлэв.

1. Гүйцэтгэх захирал Б. Тамир компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, биелэлт, санхүүгийн тайлан, 2020 оны стратеги төлөвлөгөөний талаар танилцуулав.
2. Гүйцэтгэх захирал Б. Тамир 2019 оны ашгаас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулав.
3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б. Ариунзул ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг хийж, ТУЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны төсвийг танилцуулав.

Айтүүлс ХК-ийн ТУЗ-д 12 гишүүн нэр дэвшиж Ердийн гишүүнд 6 гишүүн, хараат бус гишүүнд 3 хамгийн их санал авсан 3 гишүүнийг сонгосон.

4. ТУЗ-ийн гишүүн Г. Хатанболд Компанийн дүрэмд орох нэмэлт, өөрчлөлтийн талаар танилцуулав. Компанийн дүрмийг 2019 оны Аудитын дүгнэлт, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс 7 дугаар сарын 04-ны өдөр Айтүүлс ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн газар дээрх хэсэгчилсэн хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн нэмэлт өөрчлөлтийг орууллаа.

Аудитын дүгнэлтэд:

“Эздийн өмчид 1,338,798.0 мянган төгрөгөөр өөрчлөлт орсныг улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт хийлгэх...”

СЗХ-ны шалгалтын дүгнэлтэд:

“Улсын бүртгэлийн албанд 2011 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн бүртгүүлсэн гэрчилгээн гаргасан хувьцааны тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ зэрэг өөрчлөлтийг оруулсан гэрчилгээний хуулбарыг Хороонд ирүүлээгүй гэж тус тус заасны дагуу дараах өөрчлөлтийг оруулах шаардлагатай болсон. 100 төгрөг маань 43 төгрөг, 57 төгрөгөөрөө хуваагдаж бүртгэгдэж байгаа учраас компанийн өмчид өөрчлөлт орохгүй.

1. Компанийн дүрмийн 4.1 дүгээр заалт “Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн үнэ 100 /нэг зуун/ төгрөгийн нэрэлсэн үнэтэй 34,452,124 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ” гэж заасныг “43 /дөчин гурван/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 34,452,124 /гучин дөрвөн сая дөрвөн зуун тавин хоёр мянга нэг зуун хорин дөрөв/ ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ” гэж өөрчилнө.

2. Компанийн дүрмийн 4.2 дугаар заалт “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 3,445,212,400 төгрөг байна” гэж заасныг “1,481,441,332 /нэг тэрбум дөрвөн зуун наян нэгэн сая дөрвөн зуун дөчин нэгэн мянга гурван зуун гучин хоёр/ төгрөг байна” гэж өөрчилнө.

Мөн бусад нэмэлт, өөрчлөлтүүдийг танилцуулав.

5. ТУЗ-ийн гишүүн Н. Улаанхүү Их хэмжээний хэлцэл хийх тухай танилцуулсан бөгөөд тухайн хэлэлцүүлж байгаа асуудал нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдож буй учраас Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч буюу Айсити групп ХК нь энэхүү асуудлын санал хураалтад санал өгөөгүй болно.

-Н. Улаанхүү: Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар их хэмжээний хэлцэл буюу энэ ай си ти группийн эзэмшлийн барилгыг Айтүүлс хувьцаат компанийн эзэмшиж байгаа дуусаагүй барилгаар солих асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх ёстой байгаа. Энэ маань одоо нэгдүгээрт одоо сонирхлын зөрчилтэй бөгөөд одоо их хэмжээний хэлцүүд ангилалд тооцогдож байгаа учраас ингээд зайлшгүй энэ хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх ёстой байгаа. Энэ их хэмжээний хэлцлийн тухай асуудлыг ярихаасаа өмнө энэ асуудал яагаад үүсэх болсон тухай бас ярих нь зүйтэй байх 2017 онд Монгол банкны ерөнхийлөгчийн шийдвэрээр арилжааны банкнуудын мэдээлэлд аюулгүй байдлын тавигдах шаардлага гэсэн нэг журам

батлагдаад уг журмын дагуу арилжааны банкнууд Улаанбаатар хотоос хоёр зуун километр зайтай нөөц дата төв байгуулж үүнд харилцагчид болон банкны мэдээллүүдээ хадгалж аюулгүй байдлаа хангах ёстой гэсэн ийм шийдвэр уг журмын дагуу хэрэгжих ёстой байсан юм. Энэ журамтай холбоотойгоор Айтүүлс компани энд нэлээн томоохон зах зээл үүсэж байгаа юм байна гэж хараад, бизнесийн эрсдэл хийгээд дарханд санхүүгийн дата төв барихаар шийдвэрлээд, хөрөнгө оруулалт хийгээд, шаардлагатай хөрөнгө оруулалтыг нь болохоор IPO хийж байсан үүнийг та бүхэн санаж байгаа байх аа. Ингээд барилгын ажлаа эхлүүлээд явж байтал Монгол банкны ерөнхийлөгчийн тушаал дахиад гарч энэ шийдвэрийн хэрэгжих хугацааг 2021 он болгож хойшлуулах шийдвэр гарсан. Энэ шийдвэртэй холбоотойгоор ерөнхийдөө энэ зах зээл маань байхгүй болж хумигдсан учраас яах аргагүй Айтүүлс компанийн зүгээс барилгын ажлаа зогсоох шийдвэр гаргасан. Барилгын ажлаа зогсоосны дараа Айсити группийн зүгээс өөрийн өмчлөлийн дарханд байгаа барилгаа Айтүүлс компанид шилжүүлэн өгөөд төслийн хэрэгжилтийг цааш нь үргэлжлүүлэх нь зүйтэй юм байна гэж үзсэн. Тимй учраас “Айсити групп”-ийн өмчлөлд байгаа 1.1 тэрбум 110 сая төгрөгийн үнэ бүхий 4300 метр квадрат газар бүхий объектыг “Айтүүлс” компанийн өмчлөлд байгаа 930 сая төгрөгийн үнэ бүхий дуусаагүй үйлдвэрлэлийн барилгаар солих шийдвэрийг энэ хурлаар хэлэлцүүлж байна. Хэрвээ хувьцаа эзэмшигч та бүхэн энэ шийдвэр нь зөв, Айтүүлс компанийн үйл ажиллагаанд ашигтай, зүй зохистой юм аа гэж үзэж байвал та бүхэн саналаа өгөөд энэ асуудлыг энэ хурлаар шийдвэрлэх байгаа юм. Мөн уг шийдвэртэй холбоотой асууж тодруулах зүйл байвал Айтүүлс ХК-ийн пэйж хуудасруу мессежээр ирүүлж болно.

А. Баттамир: Энэ хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэл учраас Айсити групп энэ асуудлын санал хураалтад санал өгөхгүй.

6. Хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуулт:

Асуулт 1: Дүрмэнд оруулах өөрчлөлт нь компанийн өмчид өөрчлөлт оруулах уу?

Хариулт: А. Баттамир: Компанийн өмчид өөрчлөлт орохгүй. ТУЗ-ийн гишүүн Г. Хатанболд түрүүн танилцуулсанчлан 100 төгрөг маань 43 төгрөг, 57 төгрөгөөрөө хуваагдаж бүртгэгдэж байгаа. Тийм учраас өөрчлөлт орохгүй.

Асуулт 2: Компанийн хувьцааны үнийн уналтын талаар хариу өгнө үү. Хувьцааны үнэ өсгөх ямар арга хэмжээ авах вэ?

Хариулт: А. Баттамир: Айтүүлс ХК хувьцаа эзэмшигчдэд зориулсан мэдээллийг хөрөнгийн биржийн вэб хуудас, мөн өөрийн компанийн вэб хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх ёстой мэдээллүүдийг тогтмол өгч байгаа. Компанийн хувьцааны үнийн хувьд өнөөдрийн хаалтын ханш бол 75 төгрөг байна. Гэхдээ санхүүгийн үүднээс авч үзвэл компанийн дансны үнэ гэж байдаг өөрөөр хэлбэл компанийн бүх хөрөнгийн үнэ хувьцаа гаргахаас өмнө 61 төгрөг байсан нь одоогийн байдлаар 93 орчим төгрөг болж өссөн байгаа.

Асуулт 3: Проспектус дээр туссан модуляр дата төвийг энэ хэлэлцэж буй их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн дүнд орж ирж буй барилгаар

үргэлжлүүлнэ гэж ойлголоо. Энэ зөв үү? Эдийн засгийн ямар ашигтай тал харагдаж байгаа вэ?

Хариулт: А. Баттамир: Энэ хэлцлийг хөрөнгийн үнэлгээгээр нь аваад үзэх юм бол Айтүүлс ХК-ийн хувьд илүү ашигтай хэлцэл болсон. Дуусаагүй барилгаа шилжүүлээд маш сайн дэд бүтэцтэй буюу 35 мегабайтын цахилгаан хангамжаар тоноглогдсон, бусад дэд бүтцүүд нь хийгдчихсэн барилгаар сольж байгаа. 930,000 сая төгрөгийн үнэлгээтэй барилгыг 1,100,000,000 сая төгрөгний үнэлгээтэй барилгаар сольж байгаа нь компанийн санхүүгийн тайланд ашигтай тусч байна. Үүнээс гадна клауд систем дэлхий даяар сүүлийн 10 жил маш хүчтэй дэлгэрч байгаа бол Монгол улсад хангалтгүй байна. дэлхий 94% нь клауд руу нэвтэрчихсэн байна гэтэл манай улсад 5 хувь хүрэхгүй нэвтрэлт байна. Тийм учраас бид яах аргагүй Айтүүлс компани Улаанбаатарт ч, Дарханд ч клауд системийг нэвтрүүлж бизнесээ тэлэх, шинэ зах зээлийг нээх шаардлага тулгараад байна. Тиймээс үүний төлөө энэ хэлцлээр орж ирж байгаа барилгыг зориулах болно.

Асуулт 4: 2 жил дараалан ногдол ашиг тараасангүй. Ирэх онд ногдол ашиг хувиарлах уу?

Хариулт: А. Баттамир: Өнгөрсөн оны ногдол ашиг тараахгүй шийдвэр маань санхүүгийн дата төвийг барихад зарцуулах зорилгоор гарсан. Энэ шийдвэр маань 2019 онд маш амжилттай хэрэгжээд одоо Айтүүлс компани дээр жишээлбэл санхүүгийн дата төв маань ашиглалтад орсноор брокер, диллерийн компаниудын dbx систем Айтүүлс компани дээр ирсэн байгаа. Үнэт цаасны идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй компаниудын 80%-ийг цуглуулж чадсан байна. Дараагийн нэг зүйл нь K-mobi, zeel.mn, my credit зэрэг гар утсанд суурилсан барьцаагүй зээл олгодог системүүдийн 70-80% орчим нь Айтүүлс компанийн дата центрт цугларсан байна. Эдгээр нь өнгөрсөн оны ногдол ашиг тараахгүй шийдвэрийн бодит үр дүн юм. Энэ маань компанийн цаашдын үйл ажиллагааг сайжруулж ашиг өгөх учраас компанийн цэвэр ашиг жил ирэх тусам өсөх дүр зураг харагдаж байна. Энэ маань өөрөө маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушги гэж хандах биш мэдээллийн технологи хурдтай өсөж байгаа энэ үед өнөөдрийн олсон ашгаа дахин хөрөнгө оруулах замаар ажилласан нь илүү ашигтай, хувьцаа эзэмшигчдийн маань ч гэсэн ирээдүйн ашиг сонирхлыг илүү хангах юм байна гэдэг үүднээс ийм шийдвэр гарсан. 2019 оны хувьд ICS /Ittools cloud system/-ийг хөгжүүлэхэд зориулахаар ногдол ашиг хуваарилахгүй гэсэн шийдвэр гарсан. Ирэх жил ногдол ашиг хуваарилах эсэх нь 2020 оны санхүүгийн тайланд үндэслэж ТУЗ-ийн шийдвэрээр гарах ёстой.

Санал хураалт:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтэд нийт 17,550,148 хувьцаа эзэмшдэг 26 хүн санал өгснөөс зөвшөөрсөн 26 буюу 100%-ийн саналаар зөвшөөрөв.

2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай санал хураалтад нийт 17,435,410 ширхэг хувьцаа эзэмшдэг 23 хувьцаа эзэмшигч санал өгч 9 нэр бүхий гишүүдийг сонгов.

3. ТУЗ-ийн 2020 оны төсвийг батлах 17,550,138 хувьцааг эзэмшдэг 26 хувьцаа эзэмшигч санал өгснөөс зөвшөөрсөн 17,550,128 хувьцааг эзэмшдэг 25 хувьцаа эзэмшигч, татгалзсан 10 ширхэг хувьцааг эзэмшдэг 1 хувьцаа эзэмшигч буюу 99.99%-ийн саналаар зөвшөөрөв.

4. Компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай санал хураалтад нийт 17,549,148 хувьцаа эзэмшдэг 26 хувьцаа эзэмшигч санал өгснөөс зөвшөөрсөн 17,548,148 ширхэг хувьцааг эзэмшдэг 25 хувьцаа эзэмшигч, түдгэлзсэн 1000 ширхэг хувьцааг эзэмшдэг 1 хувьцаа эзэмшигч буюу 99.99%-ийн саналаар дэмжив.

5. Их хэмжээний хэлцэл хийх тухай санал хураалтад 3,974,694 ширхэг хувьцаа эзэмшдэг 24 хувьцаа эзэмшигч санал өгснөөс зөвшөөрсөн 3,973,384 ширхэг хувьцаа эзэмшдэг 23 хувьцаа эзэмшигч, түдгэлзсэн 1310 ширхэг хувьцаа эзэмшдэг 2 хувьцаа эзэмшигч буюу 99.97%-ийн саналаар зөвшөөрөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.

3. ТУЗ-ийн гишүүдээр дараах нэр бүхий 9 гишүүдийг сонгов.

Ердийн гишүүнд: А. Баттамир, Б. Тамир, Г. Хатанболд, Н. Улаанхүү, Б. Эрдэнэжаргал

Хараат бус гишүүнд: Л. Тэмүүлэл, З. Мягмарсүрэн, Г. Гантуяа

4. ТУЗ-ийн 2020 оны төсвийг батлав.

4. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлав.

5. Их хэмжээний хэлцэл хийх тухай тогтоолын төслийг батлав.

Хурлын дарга А. Баттамир хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлэн хурлыг хааж үг хэлснээр 16:45 цагт хурал өндөрлөв.

Хурлын тэмдэглэлд хурал дээр танилцуулсан 2 танилцуулга /PPT/-ыг хавсаргав.

Хурлын шууд дамжуулалтыг Айтүүлс ХК-ийн фэйсбүүк пэйж хуудаснаас буюу дараах холбоосоор орж үзэх боломжтой.

<https://www.facebook.com/itools.mn/videos/564988867478914/>

Тэмдэглэлтэй танилцсан:

Хурлын дарга:

А. БАТТАМИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

Б. АРИУНЗУЛ

